

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Байгаль орчны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2025/084/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Орхон аймаг
2025 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва
Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvap@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Буян-ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: Buynundrakhb@audit.gov.mn
Аудитор: А.Лхагвагэрэл
Утас: 70359826 Цахим хаяг: lkhagvagerela@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.02.25 № 70
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН БАЙГАЛЬ
ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГА
С.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Байгаль орчны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Байгаль орчны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Засгийн газрын 128 дугаар "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоолоор 2024 оны 04 дүгээр сарын 01-ээс дагаж мөрдөн, албан хаагчдын цалин нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Орхон аймгийн Байгаль орчны газрын санхүүгийн тайлангийн аудитаар АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудал

Тайлант онд Байгаль орчны газар нь 132,300.0 мянган төгрөгийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 132,237.0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаж 63.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлэн ажилласан байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орхон аймгийн Байгаль орчны газар нь байгалийн нөөц баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, орчны экологийн тэнцвэртэй байдлыг хамгаалах, хүний амьдрах эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх, байгаль орчны чиглэлээр төрөөс баримталж буй бодлогыг аймгийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх, байгаль орчны хууль тогтоомжийн биелэлтэд төрийн болон технологийн хяналт тавих, байгаль орчны мэдээлэл сургалт, сурталчилгаа явуулах, орон нутгийн онцлогийг харгалзан аялал жуулчлал хөгжүүлэхэд, байгаль орчныг хамгаалахад чиглэсэн төсөл хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэн ажилладаг орон нутгийн харьяа байгууллага юм.

Орхон аймгийн Байгаль орчны газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь экологийн тэнцвэрт байдлыг хамгаалж, байгаль орчны чиглэлээр төрөөс баримталж буй бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэн хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхэд дараах үйлчилгээг орон нутагт хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. Байгалийн нөөц баялгийг хамгаалах
2. Байгалийн нөхөн сэргээлтийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх
3. Байгалийн баялгийг зүй зохистой ашиглуулах
4. Байгалийн баялгийн төлөв байдалд мониторинг судалгаа хийж, шаардлагатай арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлэх
5. Байгаль орчны бохирдлыг бууруулж, хүний амьдрах эрүүл орчныг бүрдүүлэх
6. Байгаль хамгаалах үйлсэд иргэд байгууллага, аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлэх
7. Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ, ОНБ, иргэдийн нөхөрлөлүүдэд мэргэжлийн болон арган туслалцаа үзүүлэх
8. Бүх нийтийн экологийн боловсролыг дээшлүүлэх
9. Орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэх
10. Байгаль орчны хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж хэрэгжүүлэх

6 зорилтын хүрээнд 93 арга хэмжээ төлөвлөж 95.8 хувьтай гүйцэтгэлийн төлөвлөгөө биелсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь тайлант онд санхүү нягтлан бодох бүртгэлдээ дараах хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөж ажилласан байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Соёлын тухай хууль
- Соёлын өвийг хамгаалах тухай хууль
- Номын сангийн тухай хууль
- Музейн тухайн хууль
- Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төсвийн тухай хууль

- Шилэн дансны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлогод дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

Төсвийн тухай хуульд 8, Төрийн хэмнэлтийн тухай хуульд 3, Хөдөлмөрийн тухай хуульд 2, Төрийн албаны тухай хуульд 5 удаа, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд 4, Байгалийн ургамлын тухай хуульд 3 нэмэлт өөрчлөлт орсон байна.

Засгийн газрын 128 дугаар тогтоолоор "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг"-г шинэчлэн тогтоож, 2024 оны 04 дүгээр сарын 01-ээс мөрдөж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн Байгаль орчны газар нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл/мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2020 оны 09 дүгээр сарын 24-ны өдрийн Орхон аймгийн засаг даргын А/557 тоот захирамжаар Орхон аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн стандартаар боловсруулагдсан бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирч байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Орхон аймгийн Байгаль орчны газар нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 96,730.8 мянган төгрөгөөр буюу 12.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Бараа материал	224,282.3	201,250.0	-23,032.2
Үндсэн хөрөнгө	575,938.0	502,239.5	-73,698.6
Нийт хөрөнгө	800,220.3	703,489.5	-96,730.8
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	800,220.3	703,489.5	-96,730.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	800,220.3	703,489.5	-96,730.8

Дээрх хүснэгтээс харахад нийт хөрөнгө өмнөх оноос 96,730.8 мянган төгрөгөөр буурахад үндсэн хөрөнгийн данс, бараа материалын данс нөлөө үзүүлсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 201,250.0 мянган төгрөг болж 23,032.2 мянган төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын материалаас акталж устгасан, бусад хангамжийн материалын зарцуулалттай холбоотой, мөн үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 502,239.5 мянган төгрөг болж 73,698.6 мянган төгрөгөөр буурсан нь тоног төхөөрөмж, программ хангамжид бүртгэлтэй хөрөнгөөс акталж устгасантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 709,891.8 мянган төгрөгийг байгууллагын үндсэн үйл ажиллагаанд, аймгийн байгаль орчныг хамгаалах хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний зардалд 2,729,600.0 мянган төгрөг, зарлагыг 3,439,491.8 мянган төгрөгөөр батласан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр соёл урлаг хөгжүүлэх 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн санхүүжилт 791,499.8 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 150.0 мянган төгрөг нийт 791,649.8 мянган төгрөгийг бүрдүүлсэн.

Гүйцэтгэлээр 791,499.8 мянган төгрөгөөс 80101 - үндсэн үйл ажиллагааны зардалд 664,121.6 мянган төгрөг, 80802 - ажил олгогчоос олгох тэтгэмж шагнал урамшуулалд 101,202.4 мянган төгрөгийг зарцуулж 26,325.8 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Байгаль хамгаалах сангийн дасны зардалд 2,096,827.8 мянган төгрөгийг байгаль орчныг хамгаалах хөрөнгө оруулалтын зардалд зарцуулж Ногоон Эрдэнэт хөтөлбөрийн хүрээнд ойн мэргэжлийн байгууллагаар ойжуулалт хийлгэх 129,600.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдээгүй, бусад хөтөлбөрөөс 152,449.1 мянган төгрөг хэмнэгдэж нийт 282,049.1 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

д/д	Хөрөнгө оруулалтын ажил	Эхлэх дуусах	АИТХ-аар батлагдсан	Зарцуулалт	Үлдэгдэл
	Засаг дарга		2,729,600.00	2,484,600.00	129,600.00

1	Шилжих хөрөнгө оруулалт		2,484,600.00		
1.1	Барилга байгууламж		129,600.00		
1.1.1	Ногоон Эрдэнэт хөтөлбөрийн хүрээнд ойн мэргэжлийн байгууллагаар ойжуулалт хийх	2023-2024	129,600.00		129,600.00
1.2	Тоног төхөөрөмж		2,355,000.00	2,096,827.80	258,172.20
1	Гэр хорооллын хөрсний бохирдлыг бууруулах, хог хаягдлын менежментийг сайжруулахад тусгай зориулалтын машин, тоног төхөөрөмж, худалдан авах	2023-2024	2,355,000.00	2,222,658.23	132,341.77
2	Шинээр эхлэх хөрөнгө оруулалт		245,000.00	245,000.00	
2.1	Хөрөнгө оруулалт		240,000.00	240,000.00	
2.1.1	Гурван замын постын гүүрнээс доош Хангал голын голдирол дагуу 3 хэсэг талбайд ногоон зурвасын хамгаалалтын хашаа барих	2024	160,000.00	150,879.73	9,120.27
2.2.2.	Эрдэнэт голын голдирол дагуу буюу Далиу булгийн голын урд талд ногоон зурвас байгуулах. /800 метр хамгаалалтын хашаа хийж хөрсийг хамгаалах/	2024	80,000.00	69,012.95	10,987.05
2.2	Төсөл хөтөлбөр	497,500.0	5,000.00	5,000.00	0
2.2.1	Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, мэдээллээр хангах зорилгоор "Эх дэлхийн цаг" арга хэмжээг зохион байгуулах	2024	5,000.00	5,000.00	0
	Төвлөрүүлсэн үлдэгдэл				282,049,089

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
УЛСЫН ТӨСӨВ					
1	71411 Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	791,499.8	765,174.0	26,325.8	96.65
1.1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	685,906.1	661,775.9	24,130.2	96.48
1.2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	105,593.7	103,398.1	2,195.0	97.92

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Баян-Өндөр сумаас 132,300.0 мянган төгрөг, Орхон аймгийн засаг даргын шагнал урамшуулал 3,000.0 мянган төгрөг нийт 135,300.0 мянган төгрөгийн санхүүжилт орсноос 135,237.0 мянган төгрөгийг зарцуулж 63.0 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

д/д	Хийгдэх ажил	Санхүүжилт	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд бүх нийтээр мод тарих ажлыг зохион байгуулах	30,000.0	30,000.0	-
2	Гэр хорооллын ундны усны худгуудыг шинжилгээнд хамруулах	14,800.0	14,800.0	-
3	Бэлчээрийн худгуудын тооллого судалгааг зохион байгуулж эзэмшигчийн гэрчилгээг шинчлэн байгуулах	-	-	-
4	Байгаль орчны салбарын дэлхийн болон олон улсын тэмдэглэлт өдрүүдийг орон нутагт сурталчлах ажлыг зохион байгуулах	7,500.0	7,500.0	-
5	Ус бохирдуулагчийн тоо бүртгэл хийж, хаягдал усны дүгнэлт гаргах боломжийг бүрдүүлэх	12,000.0	12,000.0	-
6	Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс, ус хангамжийн эх үүсвэрийн тэжээгдлийн мужийн заагийг ИТХ-аар тогтоож, Хууль зүйн яаманд бүртгүүлж дэглэмийг мөрдүүлж тэмдэгжүүлэх	18,000.0	18,000.0	-
7	Ил задгай хуримтлагдсан хог хаягдлын судалгаа, цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж, хөрсний бохирдлын бууруулах	35,000.0	34,937.0	63.0
8	Байгаль орчны багц хууль тогтоомжийн хэргэжилтийг хангуулах зорилгоор холбогдох хууль хяналтын байгууллагууд, идэвхтэн байгаль хамгаалагч болон олон нийтийн байцаагчтай хамтран хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах	15,000.0	15,000.0	-
9	Аймгийн хэмжээнд мөрдөх бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн үнэлгээний шагнал урамшуулал	3,000.0	3,000.0	-
	Дүн	135,300.0	135,237.0	63.0

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагаа хийгдээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Орхон аймгийн Байгаль орчны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Лхагвагэрэл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Буян-Ундрах, газрын дарга, Тэргүүлэх аудитор П.Пүрэвлхагва нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн Байгаль орчны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 791,499.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 11,872.5 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага тухайн хуулийн 15 дугаар зүйлийн 1.2-д зааснаар 15 дугаар зүйлийн 2.1-д зааснаар байгууллагын дотуур байрны хүүхдийн хоолны хэрэглээг нэмэлт төсөвт өртөгт багтаан зарцуулсан сайн тал байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд нийт мэдээллэх 169 мэдээллээс 168 мэдээг хуулийн хугацаанд бүрэн мэдээллэсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцлийн асуудлыг үнэлэх асуудал үүсээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Орхон аймгийн Байгаль орчны газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Орхон аймгийн Байгаль орчны газрын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын аудитор О.Гантуяа хийж гүйцэтгэсэн бөгөөд албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 132 дугаартай албан бичиг, нотлох баримтын хамт Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	565.0	2	565.0	100%
Албан шаардлага	1	7,700.0	1	7,700.0	100%
Зөвлөмж	1	371.8	1	371.8	100%
Нийт дүн	4	8,636.8	4	8,636.8	100%

/мянган төгрөгөөр/

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн актын хэрэгжилт хангагдсан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагын нэмэлт санхүүжилтийн данс, байгаль хамгаалах сангийн зарцуулалт, томилолтын зардалд анхаарал хандуулах шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулсан алдаа¹ байхгүй.

Аудитаар нийт 4,363.5 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 224.0 мянган төгрөгийн 1 зөрчилд акт тогтоож, 4,139.5 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Албан хаагчийн хоолны нэмэгдлийг албан томилолтоор ажилласан хугацаанд давхардуулан 224,000 төгрөгийг илүү олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны ерөнхий үнэлгээгээр өндөр оноо авсантай холбогдуулан гаргасан аймгийн Засаг даргын 2024 оны 10 сарын 18-ний өдрийн А/767 дугаар захирамжийг үндэслэн 1,933,000 төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон

Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажилтанд ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлснийх нь төлөө эрх зүйн зөрчилтэй захиргааны актыг үндэслэж, үр дүнгийн урамшуулалтай давхардуулан 2,206,500 төгрөгийн балансын урамшууллыг олгосон дээрх 2 зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

1. Урсгал зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн 184,8 мянган төгрөгийг цалингийн зардлаас бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна.

Өгсөн зөвлөмж: Зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулалт хийхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 170/А/471305
ОРА-2025/006/НА-СТА-ТШЗ

Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Орхон аймгийн Байгаль орчны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны ерөнхий үнэлгээгээр өндөр оноо авсантай холбогдуулан гаргасан аймгийн Засаг даргын 2024 оны 10 сарын 18-ний өдрийн А/767 дугаар захирамжийг үндэслэн нийт 1,933,000 (Нэг сая есөн зуун гучин гурван мянган) төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7.3-д "Төсвийг нэг жилээр баталж, тайлагнах бөгөөд батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилан, хэрэгжилтийг зохион байгуулна", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2-д "Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно", 1.2.1-д "төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд", 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21, дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар

тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны ерөнхий үнэлгээгээр өндөр оноо авсантай холбогдуулан нийт албан хаагчдад улирлын ажлын мөнгөн урамшуулалтай давхардуулан 1,933,000 төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон зөрчлийг давтан гаргалгүй, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон аймгийн Байгаль орчны газрын дарга (С.Жаргалсайхан), нягтлан бодогч (Д.Мөнхнасан) нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР:

П.ПҮРЭВЛХАГВА

АУДИТЫН
МЕНЕЖЕР:

Б.БУЯН-УНДРАХ

АУДИТОР:

А.ЛХАГВАГЭРЭЛ



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 171/А/471305
ОРА-2025/006/НА-СТА-ТШЗ

Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Орхон аймгийн Байгаль орчны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажилтанд ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлснийх нь төлөө эрх зүйн зөрчилтэй захиргааны актыг үндэслэж, үр дүнгийн урамшуулалтай давхардуулан 2,206,500 (Хоёр сая хоёр зуун зургаан мянга таван зуун) төгрөгийн балансын урамшууллыг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"; Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2.2-д "төсвийн шууд захирагч нь байгууллагын төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид", 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан

зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлснийх нь төлөө эрх зүйн зөрчилтэй захиргааны актыг үндэслэж, үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон балансын урамшууллын 2,206,500 (Хоёр сая хоёр зуун зургаан мянга таван зуун) төгрөгийн зөрчлийг давтан гаргалгүй, биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон аймгийн Байгаль орчны газрын дарга (С.Жаргалсайхан), нягтлан бодогч (Д.Мөнхнасан) нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР:  **Ж.ПҮРЭВЛХАГВА**

АУДИТЫН

МЕНЕЖЕР:  **Б.БУЯН-УНДРАХ**

АУДИТОР:

 **А.ЛХАГВАГЭРЭЛ**



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 153/А/71305
ОРА-2025/006/НА-СТА-ТШЗ

Эрдэнэт хот

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн хийсэн Орхон аймгийн Байгаль орчны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 6 албан хаагчийн хоолны нэмэгдлийг албан томилолтоор ажилласан хугацаанд давхардуулан 224,000 (Хоёр зуун хорин дөрвөн мянган) төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Хөдөлмөрийн тухай хуулийн 123.8-д "Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно.", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.7-д "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй." гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгадагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Орхон аймгийн Орхон аймгийн Байгаль орчны газар нь томилолтын хугацаанд давхардуулан олгосон хоолны мөнгө 224,000 төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 (Ор.хүү торгуулийн орлого) тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Орхон аймгийн Байгаль орчны газрын дарга (С.Жаргалсайхан), нягтлан бодогч (Д.Мөнхнасан) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР: Д. ПҮРЭВЛХАГВА

АУДИТЫН
МЕНЕЖЕР: Б. БУЯН-УНДРАХ

АУДИТОР: А. ЛХАГВАГЭРЭЛ



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.02.25 № 124
танай -ны № -т

ОРХОН АЙМГИЙН БАЙГАЛЬ
ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГА
С.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

**2024 оны санхүүгийн тайлангийн
аудитын тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Байгаль орчны газрын 2024 оны санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийлээ.

Аудитын тайлан, аудитын дүгнэлт болон аудитаар илэрсэн 224.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 4,139.5 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 зөрчилд зөвлөмж өгч байна.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ." гэж заасныг хэрэгжүүлж төлбөрийн акт, албан шаардлагын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 30 хоногийн дотор, төлбөрийн актыг бүрэн барагдуулж, биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.ПҮРЭВЛХАГВА